

ХҮНС БАЯЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт хүнсийг амин дэм, эрдэс бодисоор үйлдвэрийн аргаар албан журмаар баяжуулах, үйлдвэрлэх, баяжуулагч бэлдмэл, баяжуулсан хүнс импортлох, экспортлох үйл ажиллагаанд тавих төрийн хяналттай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. “Хүнсний тухай”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай”, “Баяжуулсан хүнсний тухай”, “Эрүүл мэндийн тухай”, “Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай”, “Төрийн хяналт шалгалтын тухай” хууль, Засгийн газрын 2018 оны 336 дугаар тогтоолоор батлагдсан “Албан журмаар баяжуулах хүнсний жагсаалт” болон бусад холбогдох стандарт, дүрэм, журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Хүнс баяжуулах үйл ажиллагаанд тавих хяналт

2.1. Баяжуулсан хүнсний үйлдвэрлэлийн ажлын байр нь Хүнсний тухай хуулийн 10.1.1-д заасан шаардлагыг хангаж буй эсэх;

2.2. Үйлдвэрлэлд хэрэглэж буй баяжуулагч бэлдмэл нь холбогдох журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлсэн, экспортлогч улсын эрх бүхий байгууллагаас олгосон чанарын баталгаа, итгэмжлэгдсэн лабораторийн сорилын дүнтэй эсэх;

2.3. Баяжуулсан хүнсний үйлдвэрлэлд шинэ техник, технологи нэвтрүүлэх, туршилт хийсэн тухай тэмдэглэл бүртгэлтэй эсэх;

2.4. Үйлдвэрийн хүчин чадал, баяжуулсан хүнсний нэр төрөлд тавигдах стандарт, технологийн онцлогт тохируулан зориулалтын тоног төхөөрөмжийг суурилуулж, баяжуулагч бэлдмэлийг хэмжих тунлагч хэрэгслийг баталгаажуулсан эсэх;

2.5. Хүнсийг баяжуулагч бэлдмэлийг тогтоосон хэмжээ, батлагдсан орцын дагуу хэрэглэж зарцуулалтыг тооцдог эсэх;

2.6. Үйлдвэрлэгч нь баяжуулсан хүнсийг үйлдвэрлэх технологийн зааврыг боловсруулан, жор, орцыг баталж мөрддөг эсэх;

2.7. Үйлдвэрлэгч нь баяжуулсан хүнсийг зориулалтын сав, баглаа боодолд савлаж, баяжуулсан болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээг болон шошгын мэдээлэлийг холбогдох хууль, стандартын шаардлагыг дагуу бүрэн тусгасан эсэх;

2.8. Баяжуулагч бэлдмэл болон баяжуулсан хүнсийг холбогдох стандарт, дүрэм, журамд заасан нөхцөл шаардлагын дагуу хадгалж, тээвэрлэдэг эсэх.

2.9. Дотоод хяналтын лабораторид баяжуулсан хүнсний агууламжийг тодорхойлдог эсэх;

2.10. Баяжуулсан хүнсийг итгэмжлэгдсэн лабораторийн сорилын дүн, баталгаажилттай худалдаа, үйлчилгээнд нийлүүлдэг эсэх;

2.11. Баяжуулсан хүнсний нэр, төрөл, үйлдвэрлэл, борлуулалтын мэдээллийг хуульд заасан мэдээллийн санд бүртгүүлсэн эсэх;

2.12. Үйлдвэрлэгч нь ажилтнуудад хүнс баяжуулах талаарх сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулдаг эсэх;

Гурав. Баяжуулагч бэлдмэл, баяжуулсан хүнс импортлоход хяналт тавих

3.1. Баяжуулсан хүнсний тухай хуулийн 5.2-т заасан жагсаалтаар баталсан хүнс баяжуулахад хэрэгцээт найрлага бүхий баяжуулагч бэлдмэлийг импортолж байгаа эсэхэд хил, гүний хяналт тавих;

3.2. Экспортлогч улсын эрх бүхий байгууллагаас олгосон гарал үүсэл, чанар аюулгүй байдлын баталгаажуулалтын гэрчилгээтэй баяжуулагч бэлдмэл импортлосон эсэх;

3.3. Стандартчилал, техникийн зохицуулалтыг асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан стандартын шаардлагыг хангасан баяжуулагч бэлдмэл, баяжуулсан хүнсийг импортлож буй эсэх;

3.4. Баяжуулагч бэлдмэлийн чанарыг алдагдуулахгүй байх тээвэрлэлт, хадгалалтын горимыг мөрддөг эсэх;

3.5. Импортын баяжуулсан хүнс, баяжуулагч бэлдмэлийн хадгалах хугацааны гуравны хоёр нь хүчинтэй хугацаа байгаа эсэхэд хяналт тавих;

3.6. Импортын баяжуулагч бэлдмэл, баяжуулсан хүнс нь баяжуулсан болохыг илэрхийлсэн тэмдэг тэмдэглэгээтэй байна.

Дөрөв. Хариуцлага

Энэхүү журмыг зөрчсөн хуулийн этгээд, иргэнд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

	Хянасан:	
ҮҮХХ-ийн дарга		Т.Түмэнжаргал
ХЦХХ-ийн дарга		Л.Дашмягмаржав
	Боловсруулсан:	
Улсын ахлах байцаагч		Е.Цэндсүрэн
		Б.Оюунцэцэг

